



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Дүүргийн 2027 оны газар зохион байгуулалтын
төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын 3.24.2, 3.24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг улс, нийслэл, дүүргийн төлөвлөгөө, орон нутгийн төсөвтэй уялдуулан боловсруулж, иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу газар эзэмшүүлэх, өмчлүүлэх байршлыг тогтоох, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж орц, гарц нээх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар
Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны Газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтнүүд
Нарийн бичгийн дарга: Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга

2. Дээрх газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж тайлагнахыг Газар зохион байгуулалтын алба (Н.Насанбуян)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн засаг даргын шуурхай хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ



1526010672

D:\Bichig hereg\2026 on\Zahiramj\Zahiramj.docx